

ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН ГАЗРЫН 2023 ОНД АВИЛГЫН ЭСРЭГ ХУУЛЬ ТОГТООМЖ, АВИЛГАТАЙ ТЭМЦЭХ ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЧИГЛЭЛЭЭР ЗОХИОН БАЙГУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ

2023.12.10

№	Хөтөлбөрийн зорилт	Арга хэмжээ	Хугацаа	Хүрэх үр дүн	Хэрэгжилт	Хувь
1	Шударга, хариуцлагатай, ил тод нийтийн албыг бэхжүүлэх замаар авлигын эрсдэлээс урьдчилан сэргийлэх, төрийн жинхэнэ албан хаагчийн сонгон шалгаруулалт болон томилгоонд улс төрийн нөлөөллөөс ангид, мэдлэг, боловсролд суурилсан мерит зарчмыг хэрэгжүүлэх;	1.Сул орон тооны зарыг цахим хуудсандаа байршуулах, сул орон тоог нөхөхдөө Төрийн албаны дүгнэлт, Авилгатай тэмцэх газрын дүгнэлтийг үндэслэн томилох	Жилдээ	Ажлын байрны ил тод нээлттэй байдал хангагдсан байна	Энэ онд сул орон тооны 2 ажлын байрыг зарлаж, сонгон шалгаруулалтанд тэнцсэн 1 албан хаагчийг Үйлдвэр худалдаа үйлчилгээний албаны даргын албан тушаалт Төрийн албаны дүгнэлт, Авилгатай тэмцэх газрын дүгнэлтийг үндэслэн томилсон. 1 мэргэжилтний сул орон тоо сонгон шалгаруулалтаар нөхөгдсөн бөгөөд Төрийн албаны зөвлөлийн дүгнэлт ирээгүй байна. <u>Ажлын байр – Булган аймгийн хүнс, хөдөө аж ахуйн газар (hhaag.gov.mn)</u>	100%
2	Төрийн үйлчилгээний нээлттэй байдлыг хангаж, цахим үйлчилгээг хөгжүүлж чанар хүртээмжийг нь сайжруулах, үйлчлүүлэгчийн эрх ашгийг дээдэлж, төрийн албан хаагчийн хариуцлагыг дээшлүүлэх;	3.Байгууллагын вэб сайтыг нээлттэй ажиллуулж, хүртээмж чанарыг дээшлүүлэх	Жилдээ	Байгууллагын мэдээ, мэдээллийн ил тод байдал дээшилж, үйлчилгээний чанар хүртээмж сайжирна.	Байгууллагын вэб сайтыг шинэчилж, сайтаар дамжуулан төрөөс гарч буй бодлого шийдвэрийн талаарх мэдээллийг цаг алдалгүй авч хэвшсэн бөгөөд цаг үеийн болон салбарын мэдээ мэдээлэл, хууль тогтоомжийг сурталчлан үйл ажиллагааны ил тод байдлыг нэмэгдүүлж, иргэд олон нийтийн оролцоог ханган ажиллаж байна. Энэ онд 212 мэдээлэл оруулж, 3090 хандалт, сайтаар 2 иргэний хүсэлтийг ирүүлснийг холбогдох мэргэжилтэнтэй холбож шийдвэрлэсэн.	100%
		4.Салбарын чиглэлээр	Жилдээ		“Чинээлэг малчин”, “Бэлчээрийн менежмент”, “Газар тариалангийн	100%

		боловсруулж байгаа бодлогын баримт бичгийн төслийг олон нийтэд танилцуулах, харилцан санал солилцох			тогтвортой хөгжил” дэд хөтөлбөрийн хэрэгжилтийн тайланг ЗДЗ, Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн ХҮИИ дугаар хуралдаанд танилцуулж дүгнүүлсэн. <a href="http://bulgan.hhaag.gov.mn">/http://bulgan.hhaag.gov.mn</a>	
		5.Хариуцсан ажил, үүргийн чиглэлийн талаарх мэдээллийг цахим хуудсаараа нээлттэй болгох	1-р улиралд		Хариуцсан ажил, үүргийн чиглэлийн талаарх мэдээллийг цахим хуудсаараа тавьсан. <u>Байгууллагын бүтэц – Булган аймгийн хүнс, хөдөө аж ахуйн газар (hhaag.gov.mn)</u>	100%
3	Төсөв, санхүү, аудитын үйл ажиллагааны удирдлага, хяналтыг сайжруулах, ил тод байдлыг хангах, төсвийн хөрөнгө, гадаадын зээл, тусламжийг үр ашигтай, зориулалтын дагуу зарцуулах, хариуцлагыг дээшлүүлэх;	6.Тухайн жилийн төсөв Өмнөх оны төсвийн гүйцэтгэл	1-р улиралд		Байгууллагын батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулан, төсвийн харилцахын нягтлан бодох бүртгэл хөтөлж,, сар бүрийн төсвийн гүйцэтгэлийн мэдээ болон 2023 оны хагас жилийн санхүүгийн тайланг төсвийн ерөнхийлөн захирагчид хуулийн хугацаанд хүргүүлэн ажилласан. 4-р улирлын байдлаар 689.2 сая төгрөгийн төсөв батлагдсанаас 689.2 сая төгрөг зарцуулагдсан байна. Батлагдсан төсөвөөс 48.0 сая төгрөг нь мал аж ахуйн оготно устгалын ажлын зардалаар төсөвт тусгагдаж мөн бог малын үзлэг ангилалт хийх 25,3 сая төгрөгний зардлын санхүүжилт ирсэн болно. Зөвхөн төсвийн урсгал зардлын батлагдсан төсөв 12 сарын байдлаар өссөн дүнгээр 552.8 сая төгрөгийн санхүүжилт ирээд байна. <u>Санхүүгийн тайлан – Булган аймгийн хүнс, хөдөө аж ахуйн газар (hhaag.gov.mn)</u>	100%
		Дараа жилийн төсвийн төсөл /цахим хуудсандаа байршуулах			2024 оны жилийн төсвийн төслийг байршуулсан. <u>Булган аймгийн хүнс, хөдөө аж ахуйн газар (shilendans.gov.mn)</u>	100%

		7.Жилийн эцсийн санхүүгийн тайлан / цахим хуудсандаа байршуулах	2-р улиралд		2022 оны санхүүгийн хагас жилийн тайланг цахим хуудсанд болон шилэн дансны сайтад байршуулсан. <u>Булган аймгийн хүнс, хөдөө аж ахуйн газар (shilendans.gov.mn)</u>	100%
		8.Санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлт бүрэн эхээр нь цахим хуудсандаа байршуулах	2-р улиралд		Төсвийн шууд захирагчийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд энэ 4-р улирлын байдлаар 2023 оны жилийн эцсийн тайланд 2024 оны 2 сард аудит хийгдэнэ.	100%
		9.Тухайн жилийн төсөвт орсон өөрчлөлтийн талаар мэдээлэх	Хагас бүтэн жил		Энэ онд төсөвт өөрчлөлт ороогүй	-
		10.Гадаадын зээл, тусламжаар хэрэгжиж буй төсөл, хөтөлбөр, түүний хэрэгжилтийн талаарх мэдээллийг цахим хуудсандаа байршуулах	Жилдээ		Энэ онд гадаадын зээл тусламжаар төсөл хөтөлбөр хэрэгжээгүй.	-
5	Шударга ёсны үзэл санааг төлөвшүүлэн, олон нийтийг соён гэгээрүүлэх үйл ажиллагааг үе шаттай зохион байгуулж, авлигын эсрэг боловсролыг дээшлүүлэх;	11.Албан хаагчдаа соён гэгээрүүлэх үйл ажиллагааг зохион байгуулж, авлигын эсрэг боловсролыг дээшлүүлэх, зөвлөмж, гарын авлагаар хангах	Жилдээ	Авлигын эсрэг хууль тогтоомжийн талаар мэдлэг олгож, авилга үүсэх эрсдлээс урьдчилан сэргийлнэ.	Албан хаагчдын хууль эрх зүйн мэдлэг дээшлүүлэх чиглэлээр Цагдаагийн газар, ГХУСАЗСЗ-тэй хамтран Авилгын эсрэг хууль, Архидан согтуурахтай тэмцэх тухай хууль, "Цахим орчин дахь хүүхэд хамгаалал", "Гэр бүлийн хүчирхийлэл, хүүхдийн эсрэг үйлдэгдэх гэмт хэрэг, зөрчил"-өөс урьдчилан сэргийлэх чиглэлээр сургалтуудыг авч нийт 21 ажилтан, албан хаагчид хамрагдсан.	100%
		12. Авлигын эсрэг хууль тогтоомж, бэлтгэн хүргүүлсэн сурталчилгааны	Жилдээ		Авлигын эсрэг хууль тогтоомж, бэлтгэн хүргүүлсэн сурталчилгааны материалыг мэдээллийн самбар, цахим хуудаст байнга шинэчлэн	100%

		материалыг мэдээллийн самбар, цахим хуудаст байршуулж сурталчлах			байршуулж байна. НАНБХАСЗАСЗУС тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2.2, 29.2.3 дахь заалтад 2023 оны 07 дугаар сарын 07-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсныг албан хаагчдад танилцуулж, сайтад байршуулсан. Үүнд: <u>Хууль тогтоомж – Булган аймгийн хүнс, хөдөө аж ахуйн газар (hhaag.gov.mn)</u>	
		13. Ёс зүйн дүрмийг албан хаагчдад танилцуулах	Жилдээ	Албан хаагчдын хариуцлагын тогтолцоо сайжирна.	Аймгийн Төрийн албаны салбар зөвлөлөөс Төрийн албан хаагчийн Ёс зүйн тухай хууль, дүрмийн талаар нийт албан хаагчдад сургалт хийсэн. Төрийн байгууллагуудын дэргэдэх ёс зүйн хороог чадавхжуулах" сургалтанд Байгууллагын ёс зүйн зөвлөлийн 2 гишүүн хамрагдсан.	100%
		14. Зөрчлийн талаарх мэдээлэл цахим хуудсанд байршуулах, илэрсэн тохиолдолд хуульд заасан хариуцлагыг хүлээлгэсэн байх	Жилдээ		Аймгийн Төрийн албаны салбар зөвлөлөөс Төрийн албан хаагчийн Ёс зүйн тухай хууль, дүрмийн талаар нийт албан хаагчдад сургалт хийсэн.Энэ онд ёс зүйн зөрчил гаргасан албан хаагч байхгүй.	100%
		15. Зөрчлийн талаархи мэдээлэл хүлээн авах утас ажиллуулах, вэб сайтад байршуулах	Тухай бүр		Байгууллагын вэб сайтад мэдээлэл авах мэргэжилтний утасыг байршуулсан бөгөөд зөрчилтэй мэдээлэл ирээгүй.	100%
7	Төрийн хяналтын үйл ажиллагааны ил тод, нээлттэй байдлыг хангах	16.Тухайн жилд явуулах хяналт шалгалтын ажлын төлөвлөгөө, хяналт шалгалтынхаа дүн, хяналт шалгалтын мөрөөр авсан арга хэмжээ, үр дүнгийн талаар мэдээлэх	Жилдээ	Үйл ажиллагааны ил тод, нээлттэй байдлыг хангагдана.	Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 79 дүгээр тогтоол, Салбарын хяналтын газрын 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө, улсын ерөнхий байцаагчийн баталсан 08-00-05/04, 08-00-02/05, 08-00-02/06 08-00-02/13, 08-00-02/15 дугаартай удирдамжуудийн дагуу төлөвлөгөөт хяналт шалгалтаар	100%

					<p>14 хоол үйлдвэрлэлийн газар, 6 гурилан бүтээгдэхүүний цех, 1 сүү, сүүн бүтээгдэхүүний цех, 2 ус савлах цех, хүнсний худалдааны 30, газар тариалангийн 15 буюу нийт 68 объектыг 8.10.1, 8.7.1, 8.11.1, 8.20.1 кодтой хяналтын хуудсуудаар үнэлэхэд 11 бага, 42 дунд эрсдэлтэй, хууль сахин мөрдөлтийн түвшин дунджаар 66.4%, эрсдэл үүсэх магадлал дунджаар 33.5 хувьтай үнэлэгдлээ. Үүсэж болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх зорилгоор 357 хүнд мэргэжил арга зүйн зөвлөгөөг өгч, шалгалтын явцад 508 зөрчил илрүүлж, шалгалтын явцад 157 зөрчлийг арилгуулж, улсын байцаагчийн 351 заалттай 50 албан шаардлага хүргүүлж ажилласан. Албан шаардлагын биелэлт 93.6 хувьтай байна. Хүнсний худалдааны чиглэлээр хурааж, устгасан, дээж авсан тухай улсын байцаагчийн акт 6-г үйлдэж, хадгалж худалдаалах хүчинтэй хугацаа дууссан 81 нэрийн 2691200 төгрөгийн хүнсний бүтээгдэхүүнийг хурааж, зөрчил гаргасан 2 иргэнд 1 сая төгрөгийн шийтгэл ногдуулж барагдуулав. 30 объект ихээс дундруу, 9 объект ихээс багаруу, 2 объект дундаас багаруу шилжиж нийт 41 объект буюу 60.2 хувийг эзлэж буй нь хяналт шалгалт үр дүнтэй байгааг харуулж байна.</p>	
--	--	--	--	--	--	--

					<p>ХХААХҮЯ-ны салбарын хяналтын газар, улсын ерөнхий байцаагчийн баталсан 2023 оны 08-00-02/11 дугаартай удирдамжийн дагуу Монгол Улсын Ерөнхийлөгч, Ерөнхий сайдын хийсэн айлчлалын үеийн хоол хүнсний аюулгүй байдалд Хутаг-Өндөр сумын Баатарван рашаан, амралт сувилал, Булган сумын Жаран морьт зоогийн газар, Сэлэнгэ сумын Сэлэнгэ амралтын баазыг хамруулан ЭМГ-ын эрүүл ахуй халдвар, хамгааллын хяналтын улсын байцаагчтай хамтран урьдчилан сэргийлэх хяналтыг хийж, мэргэжил арга зүйн зөвлөгөөг 35 хүнд өгч ажиллав. Хяналтын явцад илэрсэн ноцтой зөрчилгүй, айлчлалд гаргасан хоолноос дээж авч СХЗ-ын хэлтсийн лабораторид хүргүүлэв. Хяналт тавьж ажилласан талаарх мэдээг ХХААХҮЯ-ны Салбарын хяналтын газарт хүргүүлэв. Хоол хүнснээс шалтгаалсан хордлого халдвар гараагүй, хүнсний аюулгүй байдал хангагдсан байна. Монгол Улсын Засгийн газрын 2023 оны "Хяналт шалгалтын төлөвлөгөө батлах" тухай 79 дүгээр тогтоол, Хүнс, хөдөө аж ахуйн хөнгөн үйлдвэрийн яамны 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө, БШУЯ, ЭМЯ, ХХААХҮЯ яамны салбарын улсын ерөнхий байцаагч нарын хамтран баталсан 03/00/21 дугаартай удирдамжаар Булган сумын 1, 2, 3, спортын дунд сургууль, 1, 2, 3, 4, 6, 7</p>
--	--	--	--	--	---

					дугаар цэцэрлэг, Бугат, Орхон сумдын сургууль, цэцэрлэгт хүнсний бүтээгдэхүүн нийлүүлдэг 2 аж ахуйн нэгж нийт 12 объектыг хамруулав. Хоол үйлдвэрлэлийн объектыг 8.10.2 кодтой хяналтын хуудсаар шалгахад эрсдэл үүсэх магадлал 4 нь дунд 6 нь бага эрсдэлтэй шалгагдлаа. Хяналт шалгалтын явцад 30 зөрчлийг илрүүлж бүрэн арилгуулсан. Шалгалтад хамрагдсан газруудын 68 хүнд холбогдох хууль тогтоомж, стандарт, дүрэм журмын талаар тайлбарлан таниулж, БСШУСайд, ЭМСайд, Сангийн Сайдын хамтарсан 2020 оны А/166, А/559, 222 дугаар тушаалын хүүхдийн хоногийн хэрэгцээг хангах хүнсний бүтээгдэхүүний жишиг хэмжээ, бүртгэл хөтлөлтийн талаар зааварчилгаа өгч ажилласан.	
8	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны ил тод байдлыг хангах, түүнтэй танилцах боломжоор хангах	17.Тендерийн баримт бичиг, тендер шалгаруулалтыг явуулах журам, тендерийн урилгыг цахим хуудсандаа байршуулсан байх	Жилдээ	Худалдан авах ажиллагааны ил тод байдлыг хангагдана.	Бэлчээрийн усан хангамжийг нэмэгдүүлэх хүрээнд орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 10 худаг гаргах тендерийг зарласан. <u>Хүн ам, бэлчээрийн усан хангамж таримал ойн услагаа арчилгаа нэмэгдүүлэх зориулалтаар шинээр худаг гаргах (Баян-Агт, Бугат, Гурванбулаг, Могод, Рашаант, Хутаг-Өндөр, Дашинчилэн, Булган, Орхон, Сэлэнгэ сүм) (tender.gov.mn)</u>	100%
		Тендерт шалгарсан болон шалгараагүй оролцогчийн талаарх мэдээлэл, Худалдан			Булган аймгийн “Булган ус” ХХК Хөдөөгийн хүн ам болон бэлчээрийн усан хангамжийг нэмэгдүүлэх зорилгоор орон нутгийн төсвийн	100%

		авсан бараа, ажил, үйлчилгээний тайланг цахим хуудсандаа байршуулсан байх			хөрөнгө оруулалтаар 10 суманд 10 худаг шинээр гаргаж хүлээлгэн өгсөн. Тайланг сайтад байршуулсан. <u>Худалдан авах ажиллагаа – Булган аймгийн хүнс, хөдөө аж ахуйн газар (hhaaq.gov.mn)</u>	
10	Иргэдийн өргөдөл гомдлыг хүлээн авч шийдвэрлэх	18.Өргөдөл /санал, мэдэгдэл/, гомдол, хүсэлт, мэдээлэл хүлээн авах нөхцөлийг бүрдүүлсэн байх (утас, хайрцаг, санал хүсэлтийн дэвтэр, факс, цахим, бичгээр, амаар г.м хэлбэрээр) Хариуцсан албан хаагчийн ажиллах журам, харилцах утас, иргэдийг хүлээн авч уулзах цагийн хуваарийг цахим хуудас болон мэдээллийн самбартаа байршуулах	Жилдээ	Иргэдийн өргөдөл гомдлыг хүлээн авах шат дамжлага цөөрч чирэгдэл багасна.	Иргэд байгууллагаас ирүүлсэн өргөдөл гомдлыг шийдвэрлэхэд хяналт тавих журам”, өргөдөл гомдол хүлээн авах хариуцсан ажилтныг томилон газрын даргын 2015 оны А/18 тоот тушаалаар батлуулж, хэрэгжүүлэв. Мөн иргэдээс гарсан гомдол санал хүсэлтийг хүлээн авах албан тушаалтан, утасыг вэб сайтад байршуулсан. <u>ӨРГӨДӨЛ ГОМДОЛ – Булган аймгийн хүнс, хөдөө аж ахуйн газар (hhaaq.gov.mn)</u>	100%
		19.Иргэдийн өргөдөл /санал, мэдэгдэл/, гомдол, хүсэлт, мэдээллийг шийдвэрлэсэн талаар мэдээг байршуулах	Улирал бүр		2023 онд 60 өргөдөл, гомдол санал хүсэлт ирсэн. Үүнээс гомдол-3, хүсэлт-53 өргөдөл-4, ирсэнээс 33 хүсэлт, 3 гомдол, 4 өргөдлийг хуулийн хугацаанд шийдвэрлээд хаасан байна. Хяналтын албанд Дүгнэлт гаргуулах 20 хүсэлт танилцуулагдаж, шийдвэрлэх шатандаа байна. <u>Өргөдөл, гомдол, санал хүсэлтийн мэдээ – Булган аймгийн хүнс, хөдөө аж ахуйн газар (hhaaq.gov.mn)</u>	90%
11	Авлигын эсрэг хууль тогтоожмийг хэрэгжүүлэх	20. 2021 оны мэдүүлэг гаргагчдыг бүртгэх, тайлан, судалгаа, нэрсийн жагсаалт хүргүүлэх	Дараа оны 2-р сарын 1-ны дотор 12 дугаар сарын 25-ны дотор	Хуулийн хугацаанд хэрэгжүүлсэн байна.	2022 оны мэдүүлэг гаргагчийн нэрсийн жагсаалтыг гаргаж, ХЗХ-т хүргүүлсэн.	100%



		21.Албан хаагчдын ХАСХОМ-г хянах, бүртгэх, тайланг хүргүүлэх	2-р сарын 10-ны дотор	Хуулийн хугацаанд хэрэгжүүлсэн байна.	Авилгын эсрэг хууль, Нийтийн ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн хэрэгжилтийг хангах хүрээнд ХАСОМ гаргагч 7 албан хаагч мэдүүлгээ хуулийн хугацаанд гаргаж, баталгаажууллаа. ХАСХОМ-ийн тайланг нэгтгэж хүргүүлэв.	100%
		22.Шинээр томилогдох тушаалтны урьдчилсан мэдүүлгийг хянуулах	Жилд	Авилгатай тэмцэх газраас ирүүлсэн дүгнэлтийг вэб сайтад байршуулсан байна.	Энэ онд хувийн ашиг сонирхолын урьдчилсан мэдүүлгийг ажил хавсран гүйцэтгэхээр 1, албан тушаал дэвшсэн 1, улсын байцаагчаар 1, нийт 3 албан хаагч хянуулж, АТГ-ын албан тоот, ТАЗ-ийн дүгнэлтээр ажилд томилсон. Эдгээр 3 албан хаагч ХАСХОМ 2022* мэдүүлгээ гаргаж байна. Мөн мэдэгдэл тайлбарыг 3 албан хаагч гаргаж, зөрчил үүсээгүй.	100%
<b>ХЭРЭГЖИЛТИЙН ХУВЬ - 99.0%</b>						